



**ХЭНГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар Б/101

Хэрлэн сум

Л.Нямдоржийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 42 дугаар зүйлийн 42.1.1, 47 дугаар зүйлийн 47,1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн жолоочоор Лхагвасүрэнгийн Нямдоржийг 2023 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:
Комиссын

дарга: Т.Баяржаргал: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн дарга

Гишүүд: Э.Ариунтунгалаг: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Няглан бодогч

Т.Баяртуяа: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нярав

3. Л.Нямдоржийн сарын үндсэн цалинг ТҮ-3 зэрэглэлээр тогтоон, 827,000 (найман зуун хорин долоон мянган) төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй

4. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоолын шийдвэр, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Л.Нямдоржид үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНТУЛГА